

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЦАЙНЫ ГАЗРЫН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР.

2021-09-13

Улаанбаатар хот

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн эд хөрөнгийг түрээслэх сонирхолтой хуулийн этгээд, аж ахуйн нэгж, иргэдээс төрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх сонгон шалгаруулалтад оролцох битүүмжилсэн материал ирүүлэхийг урьж байна

1. Цайны газрын зориулалтаар түрээслэх талбайн танилцуулга:
 - 1.1. “ДЦС-2” ТӨХК-ийн конторын 1-р давхарт байрлах 104 м.кв талбай бүхий 3 өрөө / 45.4м²- 2 өрөө - хоол бэлтгэлийн болон үйлдвэрлэлийн өрөө, 58.6м² 1 өрөө - ажилчдын хоолны заал. 1м.кв талбайн түрээсийн үнэ 10 000 төгрөг байна /
2. Сонгон шалгаруулалтад бүрдүүлэх материал.
 - 2.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар
 - 2.2. Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажил 2019 он, 2020 он)
 - 2.3. Санхүүгийн чадварыг нотлох баримт (иргэн, хуулийн этгээдийн харилцагч банкны баталгаажуулсан дансны тодорхойлолт; хуулийн этгээд 2019, 2020 оны санхүүгийн тайлан)
 - 2.4. Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхний хуулбар (5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба ажил үүргийн хуваарийн дагуу мэдээллийг бэлтгэнэ)
 - 2.5. Өөрсдийн нөөцөд байгаа хоол үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмжийн жагсаалт
 - 2.6. Үндсэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажиллагсад нь эрүүл мэндийн шинжилгээний дэвтэртэй байх, шинжилгээнд бүрэн хамрагдсаныг нотлох баримт бичиг
 - 2.7. Нийтийн хоолны чиглэлийн технологийн баримт бичиг, хоолны орц нормын хэмжээ
 - 2.8. Цайны газраас гаргах хоолны нэр төрөл, үнийн санал
3. Материал ирүүлэх
 - 3.1. Материалыг доорх хаягаар ирүүлнэ: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн байр, 3 дугаар давхар 301 тоот өрөө. Нарийн бичигт өгнө. Утас: 70172177
4. Материал шалгаруулах
 - 4.1. Материалыг 2021 оны 09-р сарын 23-ны өдрийн 16 цаг 30 минутаас өмнө дээрх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан, ирүүлсэн материалыг 2021 оны 09-р сарын 24-ний өдрийн 09 цаг 30 минутад нээнэ.

Жич: Түрээслэх байрыг ажлын өдрүүдэд 14 цагаас хойш Д.Алтантуяатай холбогдон /Утас: 70172207/ ирж үзэж болно.